



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/577

Мөрөн сум

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа газрын гадна болон дотор орчинд “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” MNS 6423:2019 стандартыг хангасан орчноо бүрэн хянах боломжтой камер суурилуулах, стандартад нийцсэн камерыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5-д заасны дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох ажлыг зохион байгуулахыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, иргэн, аж ахуй нэгжийн удирдлага, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Хууль, тогтоомж, захирамжийн хэрэгжилтийг хангаж, иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гудамж талбай, барилга байгууламжийн орчинд байршуулсан дүрс бичлэгийн техникийн ашиглалт, хамгаалалтын зааварчилгаа өгч мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (дэд хурандаа Д.Мөнхжаргал)-т даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож Засаг даргын Зөвлөлд танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар (дэд хурандаа Д.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024  
6712011122